



МНЭММН-ийн тэргүүний 2023 оны 5 дугаар сарын  
8-ны өдрийн 2 тоот тушаалын 2 дугаар хавсралт

## **НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН, СТАТИСТИКЧ ИХ, БАГА ЭМЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ШИНЭЭР АВАХ БОЛОН АХИУЛАХ ШАЛГАЛТЫН ЖУРАМ**

### **НЭГ. Ерөнхий зүйл**

1. Энэхүү журмын зорилго нь нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэг олгох шалгалтыг “Эрүүл мэндийн хууль” болон Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/513 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу зохицуулахад оршино.
2. Мэргэжлийн зэрэг олгох шалтгалт нь нийгмийн эрүүл мэндийн мэргэжлийн эзэмшихэд зайлшгүй шаардагдах мэдлэг, ур чадварын хөгжүүлэх, үнэлэх, баталгаажуулахад чиглэнэ.
3. Мэргэжлийн зэрэг нь ахлах, тэргүүлэх, зөвлөх гэсэн 3 шатлалтай бөгөөд зэргийн шалгалтыг алгасуулан олгохгүй

### **ХОЁР. Мэргэшлийн зэрэг горилогчид тавигдах нийтлэг шаардлага**

1. Мэргэшлийн зэрэг горилж буй чиглэлээр мэргэжлийн диплом эсхүл үндсэн мэргэшлийн үнэмлэхтэй байх;
2. Тухайн мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр тасралтгүй ажилласан байх,
3. Ажиллаж буй байгууллагаас тухайн мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр мэргэшлийн зэрэг горилохыг дэмжсэн байх;
4. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй байх (мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардагдах мэргэжилд хамаарна);
5. Жил тутам биелүүлсэн багц цагийн сургалтын 2/3-оос доошгүй нь тухайн ажиллаж буй мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр байх;
6. Ажилладаг байгууллага, хамт олны хөгжилд хувь нэмэр оруулах үйл ажиллагааг жил тутам зохион байгуулдаг байх
7. Тухайн мэргэжил, үндсэн мэргэшлээр ажилласан сүүлийн 5 жилд ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх;

8. Мэргэшлийн зэрэг горилохыг хүссэн өргөдлийн маягтыг цахимаар бөглөсөн, сүүлийн 3 жилдийн дотор авахуулсан цээж зургийг хавсаргасан байх

**ГУРАВ. Мэргэшлийн ахлах зэрэг горилогчид (НЭМ, статистикч их эмч) тавигдах тусгай шаардлага**

1. Тухайн мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр тасралтгүй 8-аас доошгүй ажилласан байх,
2. Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтнүүд тухайн мэргэжил/үндсэн мэргэшлийн чиглэлээр 6-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх;
3. Сүүлийн 5 жилийн хугацаанд жилд нэгээс доошгүй эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцох, ажилладаг чиглэлээрээ нийгмийн эрүүл мэндийн ач холбогдолтой үнэлгээ, шинжилгээний тайлан/дүгнэлт/санал гаргаж хэлэлцүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх),

**ДӨРӨВ. Мэргэжлийн тэргүүлэх зэрэг горилогчид (НЭМ, статистик их эмч) тавигдах тусгай шаардлага**

1. Тухайн мэргэжил/мэргэшлийн чиглэлээр 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх,
2. Байгууллагадаа дунд ба түүнээс дээд түвшний удирдах ажил хийдэг байх
3. Сүүлийн 5 жилд байгууллага/орон нутгийн түвшинд нийгмийн эрүүл мэндийн ач холбогдолтой үнэлгээ, шинжилгээний тайлан/дүгнэлт/санал гаргаж, хэлэлцүүлж үр дүнд хүрсэн байх
4. Сүүлийн 5 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд 2-оос доошгүй илтгэл 1-р зохиогчоор хэлэлцүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх),
5. Сүүлийн 5 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүлд 1-ээс доошгүй өгүүллийг 1-р зохиогчоор болон хамтран зохиогчоор хэвлүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх)

**ТАВ. Мэргэшлийн Зөвлөх зэрэг горилогчид (НЭМ) тавих тусгай шаардлага:**

- 1 Тухайн мэргэжил/мэргэшлийн чиглэлээр 25-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх,
- 2 Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр магистр, докторын зэрэгтэй байх

- 3 Горилогч нь бүс/орон нутаг/үндэсний хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр бодлого хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулдаг/зохицуулдаг, үнэлдэг түвшинд ажилладаг байх
- 4 Ажиллаж буй мэргэжил/мэргэшлийн чиглэлээр байгууллага/бүс, орон нутаг/үндэсний хэмжээнд төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт, эрдэм шинжилгээ, онол практикийн хурлыг зохион байгуулж үр дүнд хүрсэн байх;
- 5 Сүүлийн 5 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд 5-аас доошгүй илтгэл 1-р зохиогчоор хэлэлцүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх),
- 6 Сүүлийн 5 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүлд 5-с доошгүй өгүүллийг 1-р зохиогчоор болон хамтран зохиогчоор хэвлүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх),

**ЗУРГАА. Статистик бага эмчийн ахлах зэрэг горилогчид тавих тусгай шаардлага**

1. Сар, жил, улиралын статистик мэдээллийн тайланг хугацаанд нь чанартай хүлээлгэж өгдөг байх (ЭМХТ-ийн Эрүүл мэндийн мэдээллийн албаны тодорхойлолтоор баталгаажина)
2. Өөрийн хариуцсан байгууллага, орон нутгийн түвшинд мэдээллийн товхимол, эргэн мэдээлэл гаргахад гардан оролцдог байх (хувь, хуулбарыг илгээнэ)

**ДОЛОО. Статистик бага эмчийн тэргүүлэх зэрэг горилогчид тавих тусгай шаардлага**

1. Сар, жил, улиралын статистик мэдээллийн тайланг хугацаанд нь чанартай хүлээлгэж өгдөг байх (ЭМХТ-ийн Эрүүл мэндийн мэдээллийн албаны тодорхойлолтоор баталгаажина)
2. Эрдэм шинжилгээ, судалгаа, магистр, докторын ажилд зориулан өөрийн хариуцдаг өгөгдлийн сангаас мэдээлэл бэлтгэж өгөх чадвартай байх
3. Үндсэн чиг үүргийн хажуугаар нийгмийн эрүүл мэндийн аливаа арга хэмжээнд идэвхтэй оролцдог, бусдыг дагалдуулан сургадаг байх